



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/03

Улаан-Уул

Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг
хориглож, хяналт тавих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4, 7.12.1, 7.12.3 дахь заалт тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын гоц халдварт Шүлхий өвчний дэгдэлт хөрш зэргэлдээх аймаг, сумдад нэмэгдэж байгаа тул гоц халдварт өвчин дамжин, тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2022 оны 07 дугаар сарын 01-ны өдрийг дуустал тус сумын нутаг дэвсгэрт гадны аймаг сумдаас мал, амьтан худалдан авах, солилцоо хийх, тавиулаар маллах зэргээр туувраар болон тээвэрлэн байршуулахыг хориглосугай.

2. Малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр малчид, мал бүхий иргэдэд сургалт сурталчилгааг тасралтгүй зохион байгуулах, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Хөдөө аж ахуйн тасаг (О.Энхболд), Мал эмнэлгийн тасаг (О.Намжирмаа), цагдаагийн хэсэг (Т.Насанжаргал), багуудын Засаг дарга нар, мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Мал амьтны шилжилт хөдөлгөөнийг хориглосонтой холбогдуулан өөр аймаг, сумдаас мал, амьтан худалдан авсан, дамжин өнгөрүүлсэн мэдээллийг үнэн зөв цаг алдалгүй өгөх, малын шилжилт хөдөлгөөнт хяналт тавьж, илэрсэн зөрчлийг холбогдох байгууллагуудад мэдээлж амьжиргааны эх үүсвэр болсон эрдэнэт мал сүргээ хамгаалахад хамтран ажиллахыг “Хөрш айл”, малчид, иргэдэд уриалсугай.

642101157

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, захирамжийг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгжид холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий албан тушаалтнаар хариуцлага тооцуулж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Баттогтох)-д даалгасугай.



ДАРГА

Т.ЭРДЭНЭБАТ